



“Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоо их. Цаашид ч нэмэгдэх өргөн боломж бий”

Төмөрбаатарын Хулан

Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдийн холбооны Гүйцэтгэх захирал



“Монголын эрчим хүчний салбарын эмэгтэйчүүд” хэмээх энэ цувралыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөрөөс бэлтгэн хүргэж байна. Уг цуврал ярилцлагууд нь эрчүүд давамгайлсан эрчим хүчний салбарт өөрчлөлтийг авчирч, хэвшмэл ойлголтыг эвдсэн эмэгтэй манлайлагчдын түүхээс хуваалцах зорилготой юм.

Таны боловсрол эрчим хүчний салбарт ажиллахаар шийдэхэд тань нөлөөлсөн үү?

Тийм. Би 2017 онд МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийг Сэргээгдэх эрчим хүчний инженер мэргэжлээр төгссөн. Эрчим хүчний салбар эмэгтэй хүнд амаргүй, ажиллах орон зай хумигдмал гэдгийг ойлгож байсан ч өөрийн хүсэл мөрөөдлийг дагасан. Тууштай хичээж зүтгэсний үр дүнд сургуулиа төгсөх жилдээ Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдийн холбоо (СЭХҮХ) ТББ-д ажилд орж чадсан нь эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр ажиллах эхлэлийг тавьсан.

Та эрчим хүчний салбарт одоогийн эрхэлж буй ажлаа хийх хүртлээ ямар зам туулсан бэ? Тулгарсан сорилт бэрхшээлийг хэрхэн давж байсан талаараа жишээ дурдана уу?

Дээр дурдсанчлан оюутан байхдаа одоо ажиллаж буй СЭХҮХ ТББ-даа хөтөлбөрийн мэргэжилтнээр давхар ажиллаж эхэлсэн. Ажлын дадлага туршлагагүй надад бүх зүйл шинэ сорилт байсан гэхэд болно. Гишүүн байгууллагууд болон олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай харилцах, төсөл боловсруулах, судалгаа хийх зэрэг олон төрлийн ажил хийх боломж олдсон. Тэр дундаа манай байгууллагын жил бүр зохион байгуулдаг салбарын томоохон үйл явдал болох Шинэ эрчим хүчний чуулганыг 2022 болон 2023 онд хариуцан зохион байгуулахдаа олон сорилттой тулгарсныхаа хэрээр ихийг сурсан. Бүртгэл, хамтрагч байгууллагуудтай тохиролцох, илтгэгчдэд урилга явуулах зэрэг олон ажлыг нэгэн зэрэг алдаа мадаггүй гүйцэтгэснээр амжилттай зохион байгуулж дуусгасан.

Үүнээс ажлын байран дээрх өсч хөгжихөд дасан зохицох чадвар, тэсвэр тэвчээр хэр чухал болохыг ойлгосон юм. Мөн манай ажлынхан, хамтран ажиллагч байгууллагууд намайг дэмжиж байсан нь тустай байлаа.

Улмаар 2023 онд намайг СЭХҮХ ТББ-ын Гүйцэтгэх захирлаар томилсон. Үүрэг хариуцлага нэмэгдэж, олон янзын ур чадварыг надаас шаардсан ажил байв. Эхэндээ миний манлайлах чадвар хангалттай биш байна, би тохиромжтой биш байна гэсэн мэдрэмжүүд төрж байсан. Яг тэр үеэр АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөрөөс эмэгтэйчүүдийн манлайллын сургалт зохион байгуулсан нь миний энэ хандлагыг өөрчилсөн. Сул талаа хэрхэн давуу тал болгох, зөрчилт байдлыг яаж шийдвэрлэх вэ, хэрхэн хэлэлцээр хийх вэ, хамтран ажиллаж буй хүмүүстээ хэрхэн таатай ажлын орчинг бий болгох вэ гэх мэт өргөн хүрээнд тэр сургалт намайг хөгжүүлсэн. Энэ ур чадваруудад суралцсаны дараа гүйцэтгэх захирлаар ажиллахад надад давуу талууд бийг анзаарч, өөртэйгөө адил удирдах болон менежерийн ажил хийж буй залуу эмэгтэйчүүдийг дэмжихэд мөн анхаарч ажиллах болсон.

Та эрчим хүчний салбарт гаргасан ямар амжилтуудаараа хамгийн их бахархдаг вэ?

Эрчим хүчний салбар үргэлж өөрчлөгдөн шинэчлэгдэж, басхүү байнгын сорилттой тулгарч байдаг чухал салбар.

Монгол Улсын хувьд эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд алдагдалтай ажиллаж, иргэд ч үйлдвэрлэлийн өртгөө нөхөөгүй татаастай үнээр хэрэглэдэг эрчим хүчнийхээ үнэ цэнийг төдийлөн ойлгоогүй хандлагатай байдаг. Эрчим хүчний найдвартай ажиллагааны чанар муу, тасалдал ихтэй байх нь нэн ялангуяа эмзэг бүлгийн айл өрхүүд, сургууль цэцэрлэгүүдэд хүндээр тусдаг.

Энэ асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахаар манай байгууллага АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Монгол эрчим хүчний засаглал хөтөлбөртэй хамтран тархмал эрчим хүчний хангамжийг дэмжих бичил сүлжээ (микрогрид)-гээр тодорхой бүсийг эрчим хүчээр хангах талаар урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаар цаашид энэхүү төслийг хэрэгжихэд нэг алхам ойртуулсан. Энэ нь надад шинэ туршлага байгаад зогсохгүй сургууль, цэцэрлэгт хамгийн чухал асуудал болох эрчим хүчний найдвартай ажиллагааг хангахад шинэлэг, найдвартай, цэвэр эрчим хүчний системийг бий болгохоор салбарынхаа мундаг инженерүүдтэй хамтран ажиллах боломж олгосон. Энэ талын туршлага манай улсын хувьд бага учир эхэндээ амаргүй байсан. Мэдээлэл хомс байгааг үл харгалзан бид олон улсын сайн туршлагуудаас суралцаж, өөрсдийн тооцоолол дээр тулгуурлан тохирч болох хэд хэдэн системийн шийдлийг гаргаж үзсэн. Бидэнд одоогийн байдлаар тулгараад буй асуудлыг шинэлэг, байгальд ээлтэй байдлаар шийдэхэд нэг алхам болж чадах энэ ажлын нэг хэсэг байсандаа бахархалтай санагддаг.

Монголын эрчим хүчний салбарт ажиллахаар төлөвлөж буй залуу эмэгтэйчүүдэд та ямар зөвлөгөө өгөх вэ?

Дэлхийд эрчим хүчний салбарт эмэгтэйчүүд цөөнх байсаар ирсэн, Монгол Улсын хувьд ч энэ нь мөн адил байдаг. Гэхдээ Монголд шинжлэх ухаан, технологи, инженерийн чиглэлээр ажиллахаар суралцаж буй залуу эмэгтэйчүүдэд өргөн боломж бий. Миний ажигласнаар сэргээгдэх эрчим хүчний салбар нь бусад уламжлалт эрчим хүчний эх үүсвэрийн ажиллах орчинтой харьцуулахад эмэгтэйчүүдэд хамаагүй өргөн боломж олгодог. Ур чадвар сайтай, ажлаа сайн хийдэг олон эмэгтэй инженертэй таарч байлаа. Магадгүй эмэгтэйчүүд бидэнд угсралт суурилуулалтын ажил хүндрэлтэй байж болохыг үгүйсгэхгүй. Гэхдээ энэ хөгжиж буй салбарт бидэнд илүү олон ухаалаг, шийдэмгий эмэгтэйчүүд хэрэгтэй. Одоо тулгарч буй бэрхшээлүүдийг үл харгалзан Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоо их. Цаашид ч бидний оролцоо улам бүр нэмэгдэнэ гэж харж байна.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Монголын эрчим хүчний засаглал (МЭХЗ) хөтөлбөрийн тухай

АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Монголын эрчим хүчний засаглал (МЭХЗ) хөтөлбөр нь эрчим хүчний салбарын засаглалыг сайжруулах замаар Монгол Улсын эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай, төрөлжсөн, орчин үеийн, бие даасан байдлыг дэмжих зорилготой юм.

Тус хөтөлбөр нь (а) эрчим хүчний салбарын хувийн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, (б) эрчим хүчний үйлдвэрлэл болон менежментийн шинэ дэвшилтэт технологийн хэрэглээг дэмжих, (в) хүндрэлтэй нөхцөлийг тэсвэрлэх чадварыг сайжруулахын тулд өрсөлдөөнд суурилсан ил тод байдлыг бий болгох хууль эрх зүй, зохицуулалтын орчныг дэмжин ажиллана.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах имэйл хаягаар холбогдоно уу.

infomongolia@usaid.gov

Энэхүү ярилцлагыг АНУ-ын ОУХА-ийн санхүүжилттэй Монголын эрчим хүчний засаглал хөтөлбөрийн хүрээнд Абт Глобал компани бэлтгэв.